



**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

**Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт
оруулах тухай**

Монгол улсын Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэгийлэх тухай хуулийн 7 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын 2.1.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор батлагдсан Бэлчээрийн менежмент төслийн нэгж орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 2.3, 5.7 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчдын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх, ёс зүйн байдалд хяналт тавих, сахилга ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ёс зүйн хороон дарга:

Агрономч

Гишүүд:

Нягтлан бодогч

Механик инженер

Нярав, талбайн зохион байгуулагч

Нарийн бичиг:

Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн

2. Байгууллагын "Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам болон байгууллагын чиг үүргийн онцлогийг харгалзан байгууллагын хэмжээнд мөрдөх Ёс зүйн дүрмийг холбогдох дүрэмд нийцүүлэн боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/09 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

3140000005